



CFLI/FCIL

Орон нутгийн санаачилгыг
дэмжих Канад сан



*“Бид бусдын бодож
байгаагаар биш, бид
өөрсдийгөө хэн гэдгийг
мэддэг болохоор оршиж
байгаа юм.”
Лаверн Кокс*



**ТРАНС ОЛОН НИЙТЭД
ХҮРЧ ОЧИХ СТАНДАРТ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ**

Өмнөх үг

Трансжендер олон нийттэй харилцахад ашиглах энэхүү стандарт үйл ажиллагааны журам (СҮАЖ) нь үр дүнтэй байдал, ёс зүйтэй байх зорилтын хүрээнд хийгдсэн юм. Уг СҮАЖ нь хурч очих ажилтны олон талт үүргийг онцолж Транс олон нийтэд тусалж дэмждэг итгэл хүлээсэн найз байхын сацуу мэдээлэл боловсрол олгох сурган хүмүүжүүлэгчийн чиг үүргийг жигд хослуулах эрхэм үйлсэд хувь нэмэр оруулж буй юм.

СҮАЖ нь Транс олон нийтэд хүрэх үйл ажиллагаанд шаардлагатай зайлиггүй стандартуудыг тодорхойлсон бөгөөд хурч очих ажилчдыг бие даасан арга барилаа илүү боловсронгуй болгох чадавхжуулахад нөөц эх сурвалж байдлаар нэмэгдэж орж буй юм. Хурч очих ажилчдын олон талт ажлын хэв маяг, тэдний олон нийтийн сүлжээ, хувь хүний арга барилыг хүлээн зөвшөөрч, түүнд илүү тохирсон стратегийг баримталж уян хатан тогтолцоог бий болгохыг зорьсон юм. Үндсэндээ энэхүү СҮАЖ нь (1) Үр дүнг нэмэгдүүлэх (2) Ёс суртахууны зарчмуудыг үйл ажиллагаандаа баримталж ажиллах гэсэн хоёр стратегийн зорилтыг тавьж буй юм. Ингэснээр хурч очих ажилчид олон янзын, хүн хоорондын динамик нөхцөл байдалд ажлаа үр дүнтэй чиглүүлж явахад тус болно гэж үзэж байгаа юм.



Талархал

Монгол улсын Транс олон нийтэд хүрч очих энэхүү стандарт уйл ажиллагааны журам (СҮАЖ) нь Канадын Монгол дахь орон нутгийн санаачилга сан, Залуус эруул мэнд төв ТББ-ийн удирдлага захиргааны баг болон хүрч очих багийн тус дэм санхүүжилтээр бүтсэн юм. Олон нийтийг өөрсдийн үйл ажиллагаандаа аюулгүй, үр дүнтэй, ёс зүйтэйгээр татан оролцуулах энэхүү эрхэм үйлсэд хувь нэмэрээ оруулж буй хүн бүхэнд талархал илэрхийлье.



Товчилсон үгийн жагсаалт

СҮАЖ	Стандарт үйл ажиллагааны журам
ТРАНС	Трансжендэр
ЛГБТИК+	Лесби, Гей, Бисексуал, Трансжендер,Интерсекс, Күэйер+



ГАРЧИГ

Өмнөх үг	2
Талархал	3
I. Ёс зүйтэй хүрч очих:	6
1. Нууц хадгалах ба хувь хүний нууцлал хангагдах орчинг бий болгох:	7
2. Токенизмээс зайлсхийх:	10
3. Олон янз байдлыг ойлгох:	11
4. Хэвшмэл ойлголт (Стереотипүүд)-ыг анхаарч үзэх нь:	12
II. Үр дүнтэй хүрч очих нь:	15
Мэдлэг Мэдээлэл:	15
Боломжтой эрсдэлээс хамгаалах эмнэлзүйн хамгаалалтын хэрэгслүүд	16
Өртөлтийн өмнөх сэргийлэлт (PrEP):	16
Өртөлтийн дараах сэргийлэлт (PEP):	16
ХДХВ-ын халдвар илрүүлэх шинжилгээ өгөх газрууд:	16
Хууль эрх зүйн хамгаалалт:	18
Транс хүлээн зөвшөөрөх өдрүүд:	21
Олон нийтийн сүлжээ ашиглаж олон нийтэд хүрэх нь:	23
Ном зүй:	24



I. Ёс зүйтэй хүрч очих:

Трансжендэр олон нийтэд хүрч очих бүх үйл ажиллагаа, хүчин, чармайлт нь олон нийтдээ хүндэтгэлтэй, хүртээмжтэй байхаас гадна ялгаварлан гадуурхлаас ангид байхаас эхлэх ёстой.

Трансжендэр хүмүүсийн бие даасан байдлыг дэмжих нь тэдний өөрийгөө тодорхойлох эрх (хүйсийн болон бэлгийн чиг баримжаа илэрхийллийн аль ч үе шатанд байсан)-ийг хүлээн зөвшөөрч, хүндэтгэхээс эхлэх ба энэ нь транс олон нийтэд хүрч очих ажилтны ёс зүйн үндэс суурь болох юм. Өөрөөр хэлбэл тухай хүнийг байгаагаар нь хүлээн зөвшөөрөх нь транс олон нийт өөрсдийнхөө амьдралын талаар шийдвэр гаргах хамгийн чухал эрх мэдэлтнүүд гэдгийг ойлгож хүлээн зөвшөөрч буйг харуулж буй юм.

Иймд хүрч очих ажилтны ямар ч үйл ажиллагаа арга барил нь хүн бүрийг хүйс, түүний илэрхийллээс үл хамааран нэр төр, хүний эрхэм чанарыг хүндлэх мөн хүндлэгдсэн мэдрэмжийг олон нийтэд ямагт төрүүлэх нь зүйтэй.

Трансжендэр хүмүүсийн амьдралын туршлагын гол хэсэг нь өөрийгөө нээх, хүлээн зөвшөөрөх аялал байдаг ба хүйсийн баримжаагаа ойлгох, илэрхийлэх үйл явц нь гүн гүнзгий хувь хүний онцлог шинж чанартай байхаас гадна хувь хүн бүрийн замнал ихээхэн ялгаатай гэдгийг хүрч очих ажилчид ойлгож үхамсарлаж хүндэтгэлтэй ёс зүйтэй хандах хэрэгтэй.

Иймд бид трансжендэр хүмүүсийн хүний эрхэм чанарыг хүндэтгэж, өөрсдийн эрүүл мэндийн талаар мэдээлэлтэй шийдвэр гаргахад нь туслах нь бидний эрхэм үүрэг юм. Бид өөрсдийн санал болгож буй ажил үйлчилгээний ашиг тус, эрсдэлийн талаар иж бүрэн, бодитой мэдээлэл өгч байх үүрэгтэй.

Нууц хадгалах ба хувь хүний нууцлал хангагдах орчинг бий болгох нь:

Гутаан доромжлол, ялгаварлан гадуурхалттай байнга тулгардаг трансжендер олон нийттэй харьцдаг хүрч очих ажилтны хувьд тухайн хүний мэдээллийг бусадтай хуваалцахдаа өөрөөс нь зөвшөөрөл авах үгүй бол тодорхойлох боломжгүй байдлаар овог нэрийг нь нууцлан ажил хэрэгтээ ашиглах хэрэгтэй. Энэ арга барил нь хүрч очих ажлыг ёс зүйтэй болгохоос гадна урт хугацаанд хүрч очих ажлыг үр дүнтэй болгодог.

Нууцлалыг чанд сахих нь итгэлцлийг бий болгож, ирээдүйд тусламж, үйлчилгээ тогтмол авах замыг нээх ба Байгууллагын нэр хүндэд мөн эерэг нөлөө үзүүлж байдаг. Өөрөөр хэлбэл хувь хүмүүс шүүмжлэл, гүтаан доромжлолоос айхгүйгээр өөрийн амьдралын туршлагаа нээлттэй хуваалцах аюулгүй орон зайг харилцаандаа бий болгоно гэсэн үг юм.

Эцэст нь хэлэхэд, ёс суртахуунтай хүрч очих үйл ажиллагаа нь трансжендэр олон нийтийн бие даасан байдлыг хүлээн зөвшөөрч, хүндэтгэж буй ажлын арга барилыг хэлэх ба тэднийг өөрсдийгөө нээн илрүүлэх замналд дэмжлэг үзүүлэх, эрүүл мэндийн талаар

мэдээлэлтэй шийдвэр гаргахад иж бүрэн мэдээллээр хангах, цаашдаа хүрч очих ажилтан болон байгууллагад итгэх итгэлийг нэмэгдүүлэх, дэмжлэг, үйлчилгээ хайх явцад нууц чандлан хадгалагдах аюулгүй орчныг бүрдүүлэхэд оршиж буй юм.

1. Нууц хадгалах ба хувь хүний нууцлал хангагдах орчинг бий болгох:

Нууц алдахыг үл тэвчих:

ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээнд хамрагдах процессийн хувьд эхнээс нь дуусах хүртэл Транс олон нийтийн хүйс, эрүүл мэндийн мэдээлэлд хүндэтгэлтэй, мэдрэмжтэй хандаж нууцлалыг нэн тэргүүнд тавина. Цуглуулсан аливаа мэдээллийн нууцлал, түүний ач холбогдлыг онцлон тэмдэглэж олон нийтэд мэдэгдэж байх шаардлагатай. Ялгарвалан гадуурхалтад өртөж байсан, гутаан доромжлол амссан хүмүүс хувийн нууцтай холбоотой сэтгэл түгшүүр өндөр байдаг тул тэдний хувийн нууцтай холбоотой мэдээллийг хэрхэн аюулгүй боловсрууладаг талаар оролцогч трансжендэр олон нийтэд тодорхой хэлж ойлгуулавал ач холбогдол өндөр байдаг.

Бүх хүрч очих үйл ажиллагаа, хүчин чармайлт хүний эрхийн мэдрэмжтэй байх ёстой. Трансжендэр олон нийтийн 63% нь бэлгийн хүчирхийлэл болон бусад төрлийн хүчирхийлэлд хүйсийн илэрхийллээс болж өртсөн байдаг бол 29% нь трансжендэр гэдгээсээ болж амиа хорлохыг завдсан байдаг¹. Иймд трансжендэр олон нийтийн сэтгэцийн болон сэтгэл санааны тайван байдлыг нэн тэргүүнд тавьж харилцан итгэлцэл, аюулгүй байдлыг бий болгох нь чухал байдаг.

Трансжендэр олон нийтэд түгээмэл тохиолддог нийтлэг сэтгэлзүйн гэмтэл ба түүнийг илэрхийлж байдаг зан үйлийн илрэл:

Трансжендэр хүмүүс хүйсийн онцлогоосоо хамаарч хэнд ч тохиолдож болох нийтлэг сэтгэл зүйн гэмтлээс гадна дараах сэтгэл зүйн гэмтлүүдийг авч болдог. Хэдий тийм боловч бүх трансжендэр хүмүүс сэтгэлзүйн гэмтэлтэй гэж ойлгох нь учир дутагдалтай. Учир нь хувь хүний амьдралын туршлага өөр өөр байж болно.

Ялгаварлан гадуурхалт, гутаан доромжлол:

- Сэтгэлзүйн гэмтэл: Трансжендер хүмүүсийн хувьд хүйсийн баримжаагаар нь ялгаварлан гадуурхах, дарамтлах, гутаан доромжлох магадлал маш өндөр.

- Зан үйлийн илрэлүүд: Түгшүүр, сэтгэл гутрал, олон нийтийн газар явахгүй байх, эсвэл болзошгүй хор хөнөөлөөс хамгаалахын тулд нийгмийн нөхцөл байдалд өндөр сонор сэрэмжтэй ханддаг.

¹ Улаанбаатар хотын трансжендэр эмэгтэйчүдийн ХДХВ, Тэмбүүгийн Халдварын Тархалтын Тандалт, Тоог Тооцоолох Судалгаа-2021

Гэр бүл нь түүнээс татгалзах:

- Сэтгэлзүйн гэмтэл: Зарим трансжендер хүмүүсийн гэр бүл нь түүнээс татгалзсан эсвэл гэр бүлдээ хүлээн зөвшөөрөгдөөгүй байдаг.

- Зан үйлийн илрэлүүд: Сэтгэл санааны хямрал, тусгаарлагдсан ганцаардсан мэдрэмж өндөр, хүнд итгэж харилцаа тогтооход хүндрэлтэй байх, эсвэл эрсдэлтэй зан үйл хийх нь түгээмэл байдаг.

Хүчирхийлэл, үзэн ядалтын гэмт хэрэг:

- Сэтгэлзүйн гэмтэл: Трансжендер хүмүүс хүчирхийлэл, тэр дундаа үзэн ядалтын гэмт хэргийн хохирогч түүнд өртөх эрсдэл өндөр байдаг.

- Зан үйлийн илрэл: Гэмтлийн дараах стрессийн шинж тэмдэг, хэт өндөр сонор сэрэмж, бусдад итгэхэд хүндрэлтэй байх, тодорхой орчин тойрноос зайлсхийх, мансууруулах бодис хэрэглэх эрсдэл нэмэгддэг.

Эмнэлгийн Сэтгэлзүйн гэмтэл:

- Сэтгэлзүйн гэмтэл: Трансжендер хүмүүст эрүүл мэндийн үйлчилгээ авахтай холбоотой бэрхшээл түлгардаг бөгөөд энэ нь эмнэлгийн сэтгэлзүйн гэмтэлд хүргэж болзошгүй.

- Зан үйлийн илрэл: Эмнэлгийн нөхцөл байдлаас айх, шаардлагатай эрүүл мэндийн түслэмж үйлчилгээ авахаас зайлсхийх, эсвэл эмчийн үзлэгт орох үед сэтгэлийн түгшүүр ихсэх.

Дээрэлхэх, дарамтлах:

- Сэтгэлзүйн гэмтэл: Трансжендер хүмүүст, ялангуяа залуучуудад орчин үл хамаарч дээрэлхэх, дарамтлах магадлал өндөр байдаг.

- Зан үйлийн илрэлүүд: Өөрийгөө үнэлэх үнэлэмж буурах, нийгмээс хөндийрөх, эрсдэлтэй зан үйлд оролцох зэрэг нь даван туулах механизм юм.

Дотоод трансфоби:

- Сэтгэлзүйн гэмтэл: Өөрийнхөө трансжендер байдлын талаарх дотоод сөрөг итгэл үнэмшил, мэдрэмж нь гэмтлийн эх үүсвэр болдог.

- Зан үйлийн илрэл: Өөрийгөө үнэлэх үнэлэмж бага, ичих, сэтгэл гутрал, өөрийгөө тусгаарлах эсвэл өөрийгөө сүйтгэх хорлох зан үйл хийх нь элбэг.

Нийгмийн дэмжлэг дутуу:

- Сэтгэлзүйн гэмтэл: Трансжендер хүмүүс хүйсийн баримжаагаас болж найз нөхөд, гэр бүл, нийгмийн дэмжлэгээ алдаж болдог.

- Зан үйлийн илрэл: Уй гашуу, сэтгэл гутрал, шинэ холбоо тогтооход хүндрэлтэй байхаас гадна эрүүл бус даван туулах механизмд найдах магадлал өндөр.

Бичил түрэмгийлэл:

- Сэтгэлзүйн гэмтэл: Ялгаварлан гадуурхах эсвэл бичил түрэмгийллийн байнгын, нарийн хэлбэрүүд нь гэмтлийн хуримтлагдсан мэдрэмжийг бий болгодог.

- Зан үйлийн илрэлүүд: Архаг стресс, түгшүүр, бүсдад итгэхэд хүндрэлтэй байх, эсвэл харилцаа тогтоох, харилцааг хадгалахад бэрхшээлтэй байдаг.

Хүрч очих ажилтны хувьд гэмтлийн асуудалд мэдрэмжтэй хандаж, гэмтлийн нөлөөлөл нь хувь хүн бүрт харилцан адилгүй байдгийг ойлгох нь маш чухал юм. Сэтгэцийн эрүүл мэндийн дэмжлэг, түүний дотор эмчилгээ, зөвлөгөө өгөх нь Сэтгэлзүйн гэмтэл бэртэл авсан хүмүүст зайлшгүй шаардлагатай байж болно.

Иймд шаардлагатай тохиолдолд байгууллагын сэтгэлзүйчид очих бусад эх сурвалжийн талаар мэдээлэлтэй байвал зохимжтой.

Сэтгэлзүйн хувьд гэмтэл авсан транс олон нийтэд хүрч очихдоо, хүрч очих ажилтан маань дараах арга хэрэгслээс сонгон ашиглахаас гадна эмпатик хандвал зохимжтой.

Гэмтлийн тухай мэдээлэлтэй харилцах:

Мэдрэмжтэй хандах: Болзошгүй гэмтлийг өдөөгч хүчин зүйлсийг мэдэж, харилцан ярианд мэдрэмжтэй хандах. Хүндэтгэсэн, шүүмжлэлэлгүй үг хэллэг ашиглах.

Идэвхтэй сонсох:

Аюулгүй нууцлал хадгалсан орон зайг бий болгох: Хувь хүн өөрийгөө аюулгүйгээр илэрхийлэх орчинг бүрдүүлэх. Ярилцлагын үеэр нууцлал хангах. Анхааралтай сонсож, өөрийн амьдралын туршлагаа баталгаажуулж, яриаг нь таслахаас зайлсхийх. Тэдний мэдрэмж, бодлын талаар эргэцүүлэн бодох замаар өрөвдөх эмпатик сэтгэлээ харуулах нь зүйтэй.

Өөрийгөө илэрхийлэх төлөөний нэр болон хувийн шинэ чанарыг хүндэтгэх нь:

Зөв төлөөний үг ашиглах: Трансжендер хүмүүсийг хүндэтгэж, зөв төлөөний үгийг ашиглах. Энэ нь тэдний хүйсийн баримжааг хүлээн зөвшөөрч, дэмжиж байгааг харуулж буйн илрэл юм.

Эрх мэдэл ба сонголт:

Сонголтуудыг гаргаж өгөх: Сонголтуудыг санал болгож, хувь хүмүүст таатай, өөртөө эзэн болох эрх мэдэлтэй шийдвэр гаргах боломжийг олгох. Тэдний бие даасан байдал, эрх мэдлийг хүндэтгэх.

Боловсрол ба мэдлэг:

Мэдээлэл өгөх: Сэтгэлзүйн гэмтэл, сэтгэцийн эрүүл мэнд, боломжит мэдээллийн нөөцийн талаар үнэн зөв мэдээллийг хуваалцах. Хүмүүсийг даван туулах механизм, өөрийгөө арчлах стратегийн талаар сургах.

Соёлын мэдрэмж:

Соёлын хувьд мэдлэг мэдээлэлтэй байх, трансжендер олон нийтэд тулгарч буй өвөрмөц сорилтуудыг мэддэг байх. Тэдний амьдралын туршлагад соёлын хүчин зүйлс хэрхэн нөлөөлж байгаа талаар ойлголттой байх.

Таамаглахаас зайлсхий:

Нээлттэй асуулт асуу: Тухайн хүний амьдралын туршлагын талаар таамаг дэвшүүлэхээс зайлсхийх. Харин тэдний бодол санаа, мэдрэмжээ өөрийн хурдаар хуваалцах боломжийг бий олгох үүднээс нээлттэй асуултуудыг асуу.

Мэдээллийн нөөцөөр хангах:

Мэдээлэл хуваалцах: Боломжтой нөөц, туслах бүлгүүд, сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээний талаарх мэдээллийг санал болгох. Холбогдох байгууллагуудын холбоо барих хаягийг өгөх.

Тусламж хайхыг хэвийн болгох:

Гутаан доромжлолыг багасгах: Тусламж хайх нь хүч чадал гэдгийг онцлон түслэмж хүсэх зан үйлийг хэвийн болгох. Сэтгэцийн эрүүл мэндийн мэргэжилтнүүд эсвэл дэмжлэг үзүүлэх сүлжээнд холбож өгөхөд туслах.

2. Токенизмээс зайлсхийх:

Олон нийтийн төлөө ажилдаг байгууллагын хувьд бид ямар ч үнээр хамаагүй токенизмээс зайлсхийж байх ёстой:

Транс олон нийтэд түгээмэл зан суртахуун их ч тэд өвөрмөц амьдралын туршлага, зан чанартай хүмүүс гэдгийг санах ёстой. Тиймээс эдгээр хүмүүсийг зөвхөн амьдралын

туршлага эсвэл хувийн шинж чанараар нь түүний эрхэм чанарыг доошлуулж болохгүй. Өөрөөр хэлбэл, хүрч очих ажилтан нь тухайн бие хүний трансгендер тал нь түүнийг тодорхойлох цорын ганц шинж чанар биш гэдгийг ойлгох ёстой. Аливаа нэгэн хүний адил трансгендер хүн төрөл бүрийн сонирхол, зан чанар, туршлагатай гэдгийг мартаж болохгүй.

Токенизмын нэг аюултай үр дагавар бол трансгендэр олон нийтийн жинхэнэ дуу хоолой, эрх мэдэл боомилгодох эрсдэлтэй байдаг юм. Тодорхой хэвшмэл ойлголттой нийцүүлэх гэсэн дарамт нь ЛГБТКИ-ийн олон талт өгүүлэмжийг бий болгоход аяндаа хувь нэмэр оруулах ёстой дуу хоолой, туршлагын олон янз байдлыг хязгаарлаж болзошгүй байдаг юм.

3. Олон янз байдлыг ойлгох:

Трансгендер олон нийт нь дотроо олон янз байдаг бөгөөд хувь хүмүүс янз бүрийн аргаар танигдаж болно гэдгийг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Өөр өөр хүйсийн баримжаа, илэрхийлэл, туршлагыг анхаарч үзээрэй. Трансгендер олон нийт нь олон янз бөгөөд олон төрлийн хүйсийн баримжааг хамардаг. Хүйс бол нарийн төвөгтэй бөгөөд хувь хүний амьдралын туршлага гэдгийг хүлээн зөвшөөрөх нь чухал бөгөөд хувь хүмүүс өөрсдийгөө өвөрмөц байдлаар тодорхойлж ойлголт өгч болно.

Трансгендер (Транс):

Төрөхөд нь өөрт нь оноож өгсөн буюу тогтоож өгсөн хүйсээс өөрийн хүйсийн баримжаа нь ялгаатай байдаг хүмүүст зориулсан ерөнхий нэр томъёо. Трансгендер хүмүүс хоёр (эрэгтэй эсвэл эмэгтэй) туйлт байдлаас өөрөөр тодорхойлогддог.

Хоёрт туйлт байдлаас сэргийлэх:

Зөвхөн эрэгтэй, эмэгтэй хүйс гэж ялгахгүйгээр хүмүүс хоёр хүйсийн холимог, аль нь ч биш, эсвэл бүхэлдээ өөр хүйс гэж тодорхойлж болно.


Хүйсийн уян хатан байдал (флидити):

Цаг хугацаа өнгөрөхөд хүйсийн баримжаа нь өөрчлөгдөж, өөрчлөгдөж болох хувь хүмүүс. Тэд өөр өөр цэгүүдэд илүү эрэгтэй, эмэгтэйлэг эсвэл өөр хүйсийг мэдэрч болно.

Бижендэр:

Нэгэн зэрэг эсвэл өөр цаг үед хоёр өөр хүйсийн баримжаатай гэж тодорхойлсон хүмүүс.

Ажендэр:



Хүйсгүй эсвэл хүйсийн хувьд төвийг сахисан гэж тодорхойлсон хувь хүмүүс. Тэд ямар ч хүйстэй холбоотой гэдгээ мэдрэхгүй байж болно.

Хоёр сүнс (Two-spirit):

Хойд Америкийн зарим уугуул соёлууд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн аль алиныг нь агуулсан эсвэл уламжлалт хоёртын шинж чанараас гадуур хүйсийн баримжаатай хүнийг тодорхойлоход ашигладаг нэр томъёо.

Демибой/Дэмибой (Demiboy/Demigirl):

Бүрэн бус харин хэсэгчлэн эрэгтэй (демибой) эсвэл эмэгтэй (хагас охин) гэж тодорхойлсон хувь хүмүүс.

Андроген:

Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн уламжлалт зан чанарыг хослуулсан хүйсийн баримжаа илэрхийлдэг хүмүүс. Энэ нэр томъёо нь хувийн шинж чанараас илүү хүйсийн илэрхийлэлд хамаардаг.

Нейтроис (Neutrois):

Төвийг сахисан эсвэл тэг хүйстэй гэж тодорхойлсон хувь хүмүүс эрэгтэй, эмэгтэй гэсэн уламжлалт ойлголттой нийцдэггүй гэсэн үг юм.

Панжендер (Pangender):

Бүх хүйсээр ялгагдах хувь хүмүүс. Энэ нь жендерийн өргөн эсвэл хязгааргүй туршлагыг түсгасэн өргөн хүрээг багтаасан нэр томъёо юм.

Гурав дахь хүйс:

Зарим соёлд хоёроос дээш хүйсийг хүлээн зөвшөөрдөг. "Гурав дахь хүйс" гэсэн нэр томъёо нь хоёртын тооноос гадуурх хүйсийн категорийг тодорхойлоход хэрэглэгддэг.

Хижра (Hijra):

Өмнөд Азид хижра гэдэг нь хүйсийн өвөрмөц онцлогийг тодорхойлоход хэрэглэгддэг нэр томъёо юм. Хижра нь интерсекс, трансжендер, тайган (eunuch) эсвэл өвөрмөц хүйсийн шинж чанартай байж болно.

Хүйсийн сэдвийн эргэн тойронд хэл яриа байнга хөгжиж байдаг бөгөөд хувь хүмүүс өөрсдийн амьдралын туршлагыг тайлбарлахдаа янз бүрийн нэр томъёо хэрэглэж болохыг анхаарах нь чухал юм.

Хувь хүн өөрсдөдөө зориулж ашигладаг хэл, нэр томъёог хүндэтгэж, ашиглах нь тэдний мөн чанарыг илэрхийлэхэд маш чухал байдаг. Нэмж дурдахад жендэрийг хэрхэн ойлгож, илэрхийлэхэд соёлын болон бүс нутгийн өөрчлөлтүүд байдаг. Энэхүү олон талт байдлыг ойлгож, хүлээн зөвшөөрөх нь трансжендэр хүмүүст хүртээмжтэй, дэмжлэг үзүүлэх орчныг бүрдүүлэхэд зайлшгүй шаардлагатай билээ.

4. Хэвшмэл ойлголт (Стереотипүүд)-ыг анхаарч үзэх нь:

Трансжендер хүмүүстэй холбоотой хэвшмэл үг, хэвшмэл ойлголтод найдахаас зайлсхийх. урьдчилан таамагласан үзэл баримтлалд нийцэхээс илүү өвөрмөц шинж чанартай хувь хүн гэдгээр нь харьцах. Төлөөний үгэнд хүндэтгэл үзүүлж, харилцааныхаа туршид түүнийг тогтмол ашиглах. Энэ нь трансжендэр хүйсийн баримжааг хүндэтгэж буйг харуулж буй чухал алхам юм.

Аюулгүй байдал ба дагаж мөрдөх арга хэмжээ:

Трансжендер олон нийттэй харилцахдаа хэвшмэл ойлголтоос зайлсхийх нь маш чухал юм. Учир нь Стереотипүүд нь ташаа мэдээллийг хэвээр үлдээж, ялгаварлан гадуурхалтыг гааруулж байдаг, үүнээс зайлсхийх үүднээс зарим нийтлэг хэвшмэл ойлголтуудыг доор үзье.

Хоёр туйлын таамаглал:

Стереотип: Бүх трансжендэр хүмүүс "эрэгтэй" эсвэл "эмэгтэй" гэсэн ангилалд бүрэн нийцдэг гэх үзэл.

Бодит байдал: Олон трансжендэр хүмүүс хоёр туйлт системээс гадуур хоёртын бүс нонбайнари, жендерквер(genderqueer) эсвэл өөр өөр хүйсийн баримжаатай гэж тодорхойлдог.


Хүйсийн өвөрмөц байдлыг эмгэгжүүлэх:

Стереотип: Трансжендер байхыг сэтгэцийн эрүүл мэндийн асуудал гэж үзэх эсвэл хүйсийн янз бүрийн өвөрмөц байдлыг өвчин болгож эмгэгжүүлэх хандлага.

Бодит байдал: Хүйсийн олон талт байдал нь хүний амьдралын жам ёсны шинж чанар бөгөөд трансжендер байх нь сэтгэцийн эмгэг биш юм.

Мэс засалд анхаарлаа хандуулах:

Стереотип: Тухайн хүний хүйсийг тодорхойлох мэс засал хийлгэсэн эсэхээр л тухайн хүний хүйс тодорхойлогддог гэж үзэх.



Бодит байдал: Хүйсийн баримжаа нь хувь хүнийх бөгөөд баталгаажуулахын тулд эмнэлгийн тусгай журам шаарддаггүй.

Гадаад төрх байдлын талаархи таамаглалүүд:

Стереотип: Бүх трансжендэр хүмүүс хүйсийн хэвшмэл дүр төрх, хэм хэмжээг дагаж мөрдөх ёстой гэх үзэл.

Бодит байдал: Трансжендер хүмүүс хүйсийн баримжаагаа янз бүрээр илэрхийлдэг бөгөөд трансжендер байх туйлын "зөв" арга гэж байдаггүй.

Трансжендэр шилжилтийн үеийн сенсацуудад итгэх:

Стереотип: Трансжендэр олон нийтийн олон талт амьдралын туршлагыг хүлээн зөвшөөрөхгүйгээр жендэрийн шилжилтийн тухай гайхалтай эсвэл шуугиан тарьсан түүхүүдэд анхаарлаа төвлөрүүлж түүнийг бүх трансжендэрүүдийн амьдралын туршлага гэж итгэх.

Бодит байдал: Шилжилт бол хувь хүний асуудал бөгөөд хувь хүмүүс өөрсдийн хэрэгцээ, нөхцөл байдалд тохирсон янз бүрийн замаар явж болно.

Хүйсийн онцлогийг бэлгийн харьцаатай холбох нь:

Стереотип: Тухайн хүний хүйсийн онцлог нь түүний бэлгийн чиг баримжааг тодорхойлдог гэж үзэх.

Бодит байдал: Хүйсийн баримжаа болон бэлгийн чиг баримжаа нь ижил төстэй байдлын ялгаатай талууд бөгөөд нэг нь нөгөөгөө тодорхойлдоггүй.

Ил тод болгоход хэт их анхаарал хандуулах:

Стереотип: Трансжендер хүмүүсийг хүйсийн баримжаа эсвэл шилжилтийн түүхийг илчлэхийг хүлээх эсвэл дарамтлах.

Бодит байдал: Илчлэх нь хувь хүний сонголт бөгөөд бүх трансжендер хүмүүс өөрсдийн туршлагаа нээлттэй хуваалцахад таатай байдаггүй.

Трансжендер хүмүүсийг хохирогчоор дүрслэх нь:

Стереотип: Трансжендер хүмүүсийг ялгаварлан гадуурхах, хүчирхийлэлд өртдөг гэж голчлон харуулах.

Бодит байдал: Ялгаварлан гадуурхалт, хүчирхийлэл нь зарим трансжендер хүмүүст тулгардаг асуудал боловч сэтгэл хангалуун амьдралаар амьдардаг трансжендэрүүд маш олон.

Уулзвар (Интерсекшнуалити)-ыг үл тоомсорлох :

Стереотип: Трансжендер олон нийтийн үндэс үгсаа, нийгэм-эдийн засгийн байдал, хөгжлийн бэрхшээл зэрэг өвөрмөц байдлын огтлолцлыг үл тоомсорлох.

Бодит байдал: Трансжендэр хүмүүс хоорондоо огтлолцсон олон өвөрмөц байдлыг мэдэрдэг бөгөөд тэдний туршлага янз бүрийн хүчин зүйлээс шалтгаалдаг.

Трансжендер олон нийтэд үр дүнтэй хүрч, дэмжлэг үзүүлэхийн тулд хувь хүмүүст хүндэтгэлтэй хандаж, тэдний олон янзын туршлагыг хүлээн зөвшөөрч, хор хөнөөлтэй хэвшмэл ойлголтыг үргэлжлүүлэхээс зайлсхийх нь маш чухал юм. Тэдний түүхийг сонсох, хэрэгцээг нь ойлгох, хүртээмжтэй байдлыг дэмжих нь эерэг, итгэлцэл бүхий харилцааг бий болгох чухал алхам юм.

II. Үр дүнтэй хүрч очих нь:

Мэдлэг Мэдээлэл:

Хүйсийн цөөнх нь дэлхийн хүн амын 0.3-0.5 хувийг (25сая) эзэлдэг¹ бол Улаанбаатар хотод 800 орчим Трансжендэр хүмүүс оршин суудаг гэсэн тооцоо бий. ЛГБТИК+ олон нийтийн эрүүл мэндийн асуудал Монголын анагаах ухаан, ЭМ-ийн салбарт төдийлөн яригддаггүй орхигдсон сэдэв хэвээр байна². 2013 онд ЛГБТ Төв болон Хүний Эрхийн Үндэсний Комисс- оос хамтран хийсэн ЛГБТИК эрхийн нөхцөл байдал судалгаанд дурдсанаар ЛГБТИК+ хүмүүст эрүүл мэндийн үйлчилгээний чанар хангалтгүйгээс гадна эрүүл мэндийн ажилтнуудын хандлага таагүй байдаг талаар дурдсан байдаг. Судалгаанд оролцогчдын 70 хувь нь тохиолдож болох хүндрэлээс зайлсхийхийн тулд ЛГБТИК+ байдлаа нуудаг гэсэн бол 10 хувь нь эрүүл мэндийн тусламж авахад маш их хүндрэлтэй, харин тавны нэг нь ямар нэгэн асуудал гардаггүй гэсэн байна. Монголын Эрүүл Мэндийн Тусламж Үйлчилгээний бүхий л түвшинд ялгаварлан гадуурхах явдал, сөрөг хандлага түгээмэл байгаа нь дорвитой арга хэмжээ авах шаардлагатайг харуулж байна." хэмээн НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн "Монголд ЛГБТ байх нь" тайланд дурдагдсанаас гадна Транс олон нийтийн онцлог хэрэгцээнд нийцүүлсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний талаарх судалгаанд оролцогчид тусламж үйлчилгээ авахаас зайлсхийх гол шалтгаан нь "Би хаана хандахаа мэддэггүй, Надад яг ямар үйлчилгээ хэрэгтэй вэ гэдгээ мэддэггүй гэж хариулсан байдаг.

ХДХВ-ийн халдварын хувьд, Улаанбаатар хотын Трансжендэр олон нийтийн таван хувь нь ХДХВ-ийн халдвартай амьдарч байна. 2019 онд Монгол Улсад ХДХВ-ийн халдвартай

² Транс* олон нийтийн онцлог хэрэгцээнд нийцүүлсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний талаар эрүүл мэндийн мэргэжилтнүүд болон Транс* олон нийтийн мэдлэг хандлагын судалгаа, 2020-ЛГБТ Төв, Эрүүл мэндийн яам, Залуус Эрүүл Мэнд Төв ТББ

транс олон нийтийн дунд хоёр тохиолдол бүртгэгдсэн байна. ХДХВ ба БЗДХ цааш үргэлжлэн тархахаас сэргийлэх чиглэлд хүчин чармайлт гаргах хэрэгтэй байна.

Монгол Улсын эрүүл мэндийн тухай хуулийн 43.1.6-7-д Монгол улсын иргэн нь эрүүл мэндийн боловсролоо дээшлүүлэх зорилгоор эрүүл мэндийн байгууллага, ажилтнаас мэдээлэл авах, хуулийн хүрээнд өөрийн эрүүл мэндтэй холбоотой мэдээллийн нууцыг хадгалуулах эрхтэй байдаг ба Транс олон нийт өөрийн онцлог хэрэгцээнд нийцсэн чанартай эрүүл мэндийн үйлчилгээ авахын тулд эмч эмнэлгийн ажилтанд хүйс болон бэлгийн чиг баримжааны талаарх мэдээллээ өгөх шаардлагатай байдаг. Уг асуудлаар Транс олон нийтийн онцлог хэрэгцээнд нийцүүлсэн эрүүл мэндийн түслэмж үйлчилгээний талаарх судалгаанд эмч нар дараах зүйлийг хэлсэн байдаг.

Уг судалгаанд оролцсон эмч нараас эрүүл мэндийн түслэмж үйлчилгээг Транс олон нийтэд үзүүлэхэд ямар хандлагатай байдгийг тодруулахад бүх оролцогчид Транс хүмүүс бусад хүмүүстэй яг адил эрүүл мэндийн чанартай үйлчилгээ хүртэх эрхтэй гэж хариулсан.

Мөн оролцогч эмч нараас тусламж үйлчилгээ үзүүлэхэд бэлгийн чиг баримжаа болон хүйсийн чиг баримжаа хамаатай эсэхэд өвчний шалтгаан онош тогтооход хэрэгтэй гэж хэлсэн байдаг.

Эмч Ц³: Зөвлөгөө өгөхөд их хэрэгтэй. Эмэгтэй хүнд гэхэд биологийн хүйсэнд нь тохирсон зөвлөгөө өгөх хэрэгтэй болдог. Би ихэвчлэн өсвөр насны охидуудтай ажилладаг, өсвөр насанд охидуудад гардаг өөрчлөлтүүдийг нь хэлж огдог. Хөвгүүдэд ч гэсэн тэгж зөвлөгөө өгдөг.

Тэгэхлээр бэлгийн чиг баримжааг нь мэдэж байж зөв тусламж үйлчилгээ үзүүлнэ. Өөрийнх нь хүсээгүй зөвлөгөөг өгөөд байвал сэтгэл ханамж муу байна.

Эмч Б: үйлчлүүлэгчийн хүйсийн баримжаа нь маш чухал. Эмэгтэй хүн гэхэд өндгөвч, даавар гээд бүх зүйл өөр. Жишээ нь эрэгтэй хүн ороод ирэхэд биений юм ярихгүй нь тодорхой. Тиймээс эмчилгээ хийхэд мэдэх нь маш чухал

Бэлгийн чиг баримжаагаа хэлээгүй нэг үйлчлүүлэгч байсан. Цус алдсан шалтгааныг нь олж чадахгүй байсан. Гэтэл хоёлуулахнаа байх нөхцөл бүрдээд өөрт нь тайлбарлаж өгөөд цус алдалтын чинь шалтгааныг би олж чадахгүй байна гэхэд тэр хүн анусаараа бэлгийн харьцаанд орсон гэдгээ хэлсэн. Шал өөр зүйл болсон. Миний оношилгоо, эмчилгээ өөр болоод явсан. Тэгээд эмчлэх боломж бүрдсэн. Тийм учраас тэр бол маш ач холбогдолтой мэдээлэл.

³ Транс* олон нийтийн онцлог хэрэгцээнд нийцүүлсэн эрүүл мэндийн түслэмж үйлчилгээний талаар эрүүл мэндийн мэргэжилтнүүд болон Транс* олон нийтийн мэдлэг хандлагын судалгаа, 2020-ЛГБТ Төв, Эрүүл мэндийн яам, Залүүс Эрүүл Мэнд Төв ТББ

Өртөлтийн өмнөх сэргийлэлт (PrEP):

ХДХВ-ийн халдвар авах өндөр эрсдэлтэй хүмүүсийг урьдчилан сэргийлэх үр дүнтэй арга хэмжээ болох Өртөлтийн өмнөх сэргийлэлт (PrEP)-ийн талаар сургах. Трансжендер хүмүүсийг PrEP-ийн бэлэн байдал, хүртээмжтэй байдлын талаар мэдэж байгаа эсэхийг шалгаарай.

Өртөлтийн дараах сэргийлэлт (PEP):

ХДХВ-ийн халдвар авсан байж болзошгүй хүмүүст өртсөний дараах урьдчилан сэргийлэх Өртөлтийн дараах сэргийлэлт (PEP) талаар мэдээлэл өгөх. Энэ нь онцгой байдлын үед маш чухал мэдээлэл байж болно.

ХДХВ-ын халдвар илрүүлэх шинжилгээ өгөх газрууд:

ЛГБТКИ+ олон нийтийн эмнэлэг (Залуус Эрүүл Мэнд Төв ТББ) болон бусад олон нийтэд хүртээмжтэй ХДХВ-ийн халдварын шинжилгээ хийх боломжтой газруудыг тодорхой зааж өгөх. Боломжтой бол өөрийгөө шинжлэх иж бүрдэл (Oraqwick) гэх мэт арга хэрэгслүүдийн талаар ярилцах.

Нийтлэг төөрөгдөл ба Залруулга:

Төөрөгдөл: PrEP нь ХДХВ-ээс урьдчилан сэргийлэхэд 100% үр дүнтэй байдаг.

Залруулга: PrEP нь өндөр үр дүнтэй боловч 100% алдаа гаргалгүй, үр дүнтэй биш. Тогтвортой, зөв хэрэглэх нь эрсдлээс хамгаалах үр дүнг нэмэгдүүлж байдаг.

Төөрөгдөл: PrEP нь зөвхөн өндөр эрсдэлтэй зан үйл хийдэг хүмүүст зориулагдсан.

Залруулга: PrEP нь ХДХВ-ийн халдвар авах өндөр эрсдэлтэй хүмүүст зориулагдсан боловч энэ нь янз бүрийн хүмүүст, тэр дундаа серодискордант (serodiscordant) харилцаатай хүмүүст урьдчилан сэргийлэх сонголт байж болно.

Төөрөгдөл: PrEP авах нь бэлгэвч хэрэглэх шаардлагагүй гэсэн үг юм.

Залруулга: PrEP нь ХДХВ-ийн халдвар дамжих эрсдлийг бууруулдаг боловч бэлгийн замаар дамжих бүсэд халдвараас (БЗДХ) хамгаалдаггүй. PrEP-ийг бэлгэвч хэрэглэхтэй хослуулах нь нэмэлт хамгаалалт болдог.

Төөрөгдөл: ХДХВ-ийн халдвар авсаны дараа ямар ч үед PEP авч болно.

Залруулга: PEP нь өртсөнөөс хойш 72 цагийн дотор эхлэхэд хамгийн үр дүнтэй байдаг, гэхдээ эрт байх тусмаа сайн. Үүнийг тогтоосон хугацаанд тогтмол уух хэрэгтэй.

Төөрөгдөл: PEP бол ХДХВ-ийн эмчилгээ биш.

Залруулга: PEP нь ХДХВ-ийн эмчилгээ биш юм. Энэ нь болзошгүй эрсдэлд өртсөний дараа ХДХВ-ийн халдвар дамжих эрсдлийг бууруулахад түсалдаг яаралтай урьдчилан сэргийлэх арга хэмжээ юм.

Төөрөгдөл: ХДХВ-ийн шинжилгээг зөвхөн мэргэжлийн эмнэлгүүдэд хийдэг.

Залруулга: Байршил харгалзахгүй авч хэрэглэж болно. Одоогоор Монголд Залуус Эрүүл Мэнд Төв, Төгс Бүсгүйчүүд гэх мэт олон нийтэд тулгуурсан эмнэлэгүүд бас хийдэг....

Төөрөгдөл: Өөрийгөө шинжлэх иж бүрдэл нь эмнэлэгт хийсэн шинжилгээнээс бага нарийвчлалтай байдаг.

Залруулга: Эрүүл мэндийн байгууллагаас зөвшөөрөгдсөн өөрийгөө шинжлэх шинжилгээний иж бүрдэл нь өндөр нарийвчлалтай байдаг.

Төөрөгдөл: Тогтмол эрүүл мэндийн түслэмж үйлчилгээ нь урьдчилан сэргийлэх зорилгоор биш зөвхөн эрүүл мэндийн тодорхой асуудалд шаардлагатай байдаг.

Залруулга: Эрүүл мэндийн түслэмж үйлчилгээнд тогтмол очиж үзүүлэх нь өөрийн эрүүл мэндийг хамгаалахад зайлшгүй шаардлагатай. Тогтмол үзлэг нь бэлгийн эрүүл мэнд, сэтгэцийн эрүүл мэнд, ХДХВ-ийн халдварын шинжилгээ зэрэг урьдчилан сэргийлэх түслэмж үйлчилгээг авах боломжийг мөн олгодог.

Хууль эрх зүйн хамгаалалт:

Үндсэн хуулиар баталгаажсан хувь хүний халдашгүй байх эрх

Хүний эрхийн хамгаалалтын үндсэн шинж нь түүний халдашгүй байх тухай асуудал байдаг. Монгол улсын үндсэн хуулийн 16.13 дахь хэсэгт заасны дагуу Монгол улсын иргэн халдашгүй чөлөөтэй байх эрхтэй. Мөн түүнчлэн иргэний хувийн болон гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална хэмээн үндсэн хуульд заасан байдаг.

Үндсэн хуулийн эл зохицуулалтыг хангахаар 1995 онд Хувь хүний нууцын тухай хуулийг батласан байдаг. Хувийн нууцаа хадгалуулах эрх нь иргэний хувийн эрх, эрх чөлөөнд хамаарах суурь эрх байдгаараа онцлогтой. Үндсэн хуулийн 16.13 дахь хэсгийн халдашгүй чөлөөтэй байх эрхийг эрдэмтэн судлаачид нийтлэг байдлаар бие махбодийн халдашгүй байх эрх талаас нь онцлон тодорхойлж судалсаар ирсэн. Тухайлбал хуульд заасан үндэслэл журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих баривчлах хорих мөрдөн мөшгих эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно гэж үндсэн хуульд тусгасан ба холбогдох эрүүгийн хууль тогтоомжоор хэлбэржсэн байдаг.

Хувь хүн зөвхөн өөрт болон өөрөөс шууд хамааралтай дотны хүмүүст хамаарах мэдээллийг бусдаас нууцлах ашиг сонирхол хэзээд ч хадгалагдаж байдаг учраас түүнийгээ нууцлах эрхийг нь Үндсэн хуулиар баталгаажуулсан байдаг.

Үүний илрэл нь Монгол улсын эрүүгийн хуульд хүн өөрийн гэр бүлийн гишүүний эсрэг мэдүүлэг өгөхгүй байж болдог. Монгол улсын хууль зүйн шинжлэх ухаанд хувь хүний халдашгүй байдлыг зөвхөн бие махбодийн хувьд авч үздэг уламжлал байсан бол уг концепт өргөжих хэрэгцээ шаардлага мэдээллийн халдашгүй байдлын ач холбогдол

нэмэгдэж буй энэ үед бий болж байна. 2021 онд 1995 оны Хувь хүний нууцын тухай хууль шинэчлэгдэж Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль болсон. Уг хуульд хүйсийн болон бэлгийн чиг баримжаатай холбоотой мэдээллийг хүний эмзэг мэдээлэлд тооцож тухайн хүний зөвшөөрөлгүй бусад хүмүүст уг мэдээллийг задруулсан бол хууль эрх зүйн хариуцлага хүлээлгэх болсон.

Ингэснээр өмнө нь хүйсийн болон бэлгийн чиг баримжаагаар дулдуйдаж бусдыг шантайчилж мөнгө авах, нэр хүндийг унагаах зорилгоор олон нийтийн сүлжээнд тавьж бэлгийн болон хүйсийн цөөнхийн хүний эрхийг ноцтой зөрчдөг байсан бол одоо уг зөрчилд хариуцлага тооцдог механизм бий болж буй юм.

Монгол Улсын Иргэний улсын бүртгэлийн тухай хууль:

Монгол Улсын иргэний улсын бүртгэлийн тухай хууль /ИУБТХ/ -ийн 5 дугаар зүйлийн 5.6-д хүйс солих асуудлыг зохицуулсан байдаг. ИУБТХ-ийн 14.1-д 18 нас хүрсэн иргэн хүйсээ солиулж иргэний улсын бүртгэлд бүртгүүлэхийг хүсвэл дараах материалыг бүрдүүлэн улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад биечлэн бүртгүүлнэ гэж заасан байдаг.

Уг зохицуулалт нь нэг талаар хүйсийн цөөнх тэр дундаа Трансжендэр олон нийт хүйсээ солиулах боломжийг хууль эрх зүйн орчинд олгож буй ч бүрдүүлэх баримт бичгийн жагсаалтад *хүйсийн өөрчлөлтийг баталгаажуулсан эмнэлгийн баримт бичиг, гэрлэлтийг цуцлах тухай эрх бүхий байгууллагын шийдвэрийг оруулах ёстой* нь Транс олон нийтийг заавал мэс ажилбарт оруулж олон нийтийн эрүүл мэндийг өндөр эрсдэлж оруулахыг тулгаж буй харгис явдал юм.

Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Сайдын Хамтарсан Тушаал Дугаар А/758, А/197-тушаал

Хууль тогтоомжид заасны дагуу нийгмийн даатгалын шимтгэл төлж байсан иргэн ХДХВ-ын халдвартай болох нь тогтоогдсон бол хөдөлмөрийн чадвар алдсаны сар бүрийн тэтгэмжийг авдаг. Харин 2024 оны 1-р сарын 1-ээс мөрдөгдөх Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд Тэтгэврийн даатгалын шимтгэлийг 20-иос доошгүй жил, эсхүл хөдөлмөрийн чадвараа алдахын өмнөх сүүлийн 5 жилд нийтдээ 36 ба түүнээс дээш сар төлсөн даатгуулагч ердийн өвчин, ахуйн ослын улмаас хөдөлмөрийн чадвараа 50 ба түүнээс дээш хувиар алдсан бол хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй болсон.

Хөдөлмөрийн чадвар алдсаны бүрэн тэтгэврийн хэмжээг энэ хуулийн доорх томъёогоор тооцон уг тэтгэврийн хэмжээнээс хөдөлмөрийн чадвараа 70 ба түүнээс дээш хувиар алдсан бол 100 хувиар, 50-69 хувиар алдсан бол хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээгээр тус тус бодож тооцно.

$$T_{цб} = Ц * (45\% + (Ш_{241+} * 0.125\%))$$

$T_{цб}$ -цалинд үндэслэсэн аргаар тооцсон бүрэн тэтгэврийн сарын хэмжээ;

Ц-энэ хуулийн 20.1-д заасны дагуу тооцсон сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлого;

$Ш_{241+}$ -241 ба түүнээс дээш шимтгэл төлсөн сарын тоо.

ДОХ, ХДХВ-ийн халдвар авсан нийгмийн даатгал төлөгч нь ердийн өвчин ахуйн ослын улмаас хөдөлмөрийн чадвар алдсан ангилалд тооцогддог ба хөдөлмөрийн чадвар алдалтын хувийг доорх байдлаар тооцдог байна.

ДОХ, ХДХВ-ийн халдварын 1-4 дүгээр шат	а/ ХДХВ-ийн халдварын эмнэлзүйн I-II үе шат (Ретровирусийн эсрэг эмчилгээнд 12 сар ба түүнээс дээш хугацаанд >95% тууштай хамрагдсан)	B20 B21 B22 B23	60	2 жил
	б/ ХДХВ-ийн халдварын эмнэлзүйн III үе шат (Ретровирусийн эсрэг эмчилгээнд 6 сар ба түүнээс дээш хугацаанд >95% тууштай хамрагдсан)	B24	70	2 жил
	в/ ХДХВ-ийн халдварын эмнэлзүйн IV үе шат- ДОХ (Ретровирусийн эсрэг эмчилгээ эхэлсэн байх)		80	2 жил

Харин нийгмийн даатгал төлж байгаагүй бол Нийгмийн халамжийн тухай хуульд зааснаар нийгмийн халамжийн тэтгэмж авах ба хэрэв 65 насанд хүрсэн бол нийгмийн халамжийн тэтгэвэр авдаг. Тэтгэвэр, тэтгэмж тогтоолгон авахыг хүссэн иргэн холбогдох баримт бичгийг бүрдүүлж, өргөдлийн хамт сум, хорооны нийгмийн ажилтанд өгнө.

Сум, хорооны нийгмийн ажилтан тэтгэвэр, тэтгэмж тогтоолгох өргөдлийг хүлээж авснаас хойш 30 хоногийн дотор хянан шийдвэрлүүлнэ. Тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг тухайн үед мөрдөж байгаа хүн амын амьжиргааны доод түвшингийн хэмжээг үндэслэн Засгийн газар тогтоох ба одоогоор мөрдөгдөх буй 2023 оны Засгийн газрын 237 дугаар тогтоолоор Нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээг сард 325,000.0 (гурван зуун хорин таван мянга) төгрөгөөр, асаргааны тэтгэмжийн хэмжээг сард 275,000.0 (хоёр зуун далан таван мянга) төгрөгөөр тус тус тогтоосон байна.

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль:

2022 оны 7 дугаар сарын 2-ны өдрөөс эхлэн даган мөрдөж буй Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль (Шинчилсэн хөдөлмөрийн хууль)-ийн 6 дугаар зүйлийн 6.1-д Ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, нийгмийн болон гэрлэлтийн байдал, хөрөнгө чинээ, шашин шүтлэг, үзэл бодол, улс төрийн үзэл бодол, үйлдвэрчний эвлэлийн гишүүн эсэх, эрүүл мэндийн байдал, жирэмсэн болон амаржсан эсэх, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, илэрхийлэл, хөгжлийн бэрхшээл, гадаад төрхөөр нь шууд, эсхүл шууд бусаар ялгаварлан гадуурхах, эрхийг нь хязгаарлах, давуу байдал олгохыг хориглоно гэж заасан байдаг.

Шинэчилсэн Хөдөлмөрийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д мөн ажил олгогч нь хөдөлмөрийн харилцаанд орохоос өмнө болон ажиллах хугацаанд ажилтнаас ажилтай холбоогүй асуулт асуух, мэдээлэл цуглуулах, эрүүл мэнд, сэтгэл зүй, ХДХВ, жирэмсний тест хийлгэхийг шаардахыг хориглоно гэж заасан байдаг.

Хөдөлмөрийн тухай хуулийн 6.4-т ажилд горилогч, ажилтан нь энэ хуулийн 6.5-д заасныг зөрчсөн ажил олгогчийн өмнө үнэн зөв хариулах, мэдээлэл өгөх, шинжилгээнд хамруулах үүрэг хүлээхгүй гэж заасан.

Монгол Улсын Эрүүгийн хууль:

Монгол Улсын Эрүүгийн хууль/Эрүүгийн хууль/-ийн 1.3 дугаар зүйлийн 2-т гэмт хэрэг үйлдэх, ял оногдуулахдаа харьяалал, үндэс угсаа хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал үүсэл, нийгмийн болон гэр бүлийн байдал, хөрөнгө чинээ, шашин шүтлэг, итгэл үнэмшил, улс төрийн итгэл үнэмшил, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, илэрхийлэлээр ялгаварлан гадуурхахыг хориглоно гэж заасан.

Эрүүгийн хуулийн 2.14-т үндэс угсаа, арьсны өнгө, шашин шүтлэг, итгэл үнэмшил, улс төрийн итгэл үнэмшил, бэлгийн болон хүйсийн чиг баримжаагаар үзэн ядах сэдлээр хүн амины хэрэг үйлдсэн бол 12-20 жил хүртэл хугацаагаар хорих, эсхүл бүх насаар нь хорих ял шийтгэнэ гэж мөн заасан байдаг.

Эрүүгийн хуулийн 14.1 дүгээр зүйлд заасан ялгаварлан гадуурхах гэмт хэргийг зүйлчилсэн байх хэдий ч н хүнийг ялгарвлан гадуурхаж эрх эрх чөлөөг хязгаарласан гэдгийг хууль зүйн шинжлэх ухааны өнөөгийн практикт хувь хүний бие мах бодийн хүрээнд хязгаарлалт тогтоодог ба идэвхтэй үйлдэл хийсэн байхыг шаарддаг. Жнь: Тухайн хүнийг хулгайлах, эрхшээлдээ байлгах гэх мэт идэвхтэй үйлдлээр илэрч болно. Одоогоор уг зүйл заалтаар ял авсан нэг ч практик байхгүй ба Монгол улсын дээд шүүх хүртэл явсан 1 шүүхийн практик байдаг ч эрх эрх чөлөөг хязгаарласан идэвхтэй үйлдэл тогтоогдохгүй байна гэдэг үндэслэлээр ял оноогоогүй билээ.

Эрүүгийн хуулийн-14.1-д Хүнийг түүний үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг,

үзэл бодол, боловсрол, бэлгийн, хүйсийн чиг баримжаа, эрүүл мэндийн нөхцөл байдлаар ялгаварлан гадуурхаж эрх, эрх чөлөөг нь хязгаарласан бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ гэж заасан байдаг.

Хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль:

Монгол Улсын “Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль”(Хувийн нууцын тухай хууль)-ийн 3 дугаар зүйлийн 3.9.1-д хүний эрүүл мэнд, захидал харилцаа, удамшлын болон биометрийн мэдээлэл, цахим гарын үсгийн нууц үг, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, илэрхийлэл, бэлгийн харилцааны талаарх эмзэг мэдээлэл энэ хуулийн 4.1.12-т хувийн нууцад хамаарна.

Хувийн нууцын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3-д хувийн нууцад хамаарах нууц мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах явцад хүний эрх, эрх чөлөөг зөрчихөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс /цаашид “Хүний эрхийн үндэсний комисс” гэх мэдээлэл цуглуулагчдад зөвлөмж өгч болно.

Дээрх хуультай холбоотойгоор Монгол улсын зөрчлийн тухай хууль (Зөрчлийн тухай хууль)-ийн 6.27-д хувийн нууцад хамаарах мэдээллийг хууль бусаар олж авсан, боловсруулсан, дамжуулсан, задруулсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хувь хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр (нэг нэгжийг 1000₮) торгоно гэж заасан.

Монгол улсын эрүүл мэндийн тухай хууль:

Монгол улсын эрүүл мэндийн тухай хуулийн 43-р дугаар зүйл эрүүл мэндийн чиглэлээр иргэний эрх үүрэг аж ахуй, байгууллага олон нийтийн оролцооны талаар тусгаж өгсөн бөгөөд үүнд дараах хэд хэдэн чухал зүйлүүдийг дурдсан байдаг. Үүнд:

- Иргэн эрүүл мэндээ хамгаалах талаар дараах эрх эдэлнэ:
- эмч, эрүүл мэндийн байгууллагаас түслэмж, үйлчилгээ авах;
- Өрхийн эмчээ сонгон бүртгүүлэх;
- өөрийн эрүүл мэндийн тухай мэдээллийг эмч, эрүүл мэндийн байгууллагаас авах;
- Халдварт өвчнөөс бусад тохиолдолд эмчилгээ, оношлогоо, шинжилгээ хийлгэхээс татгалзах;
- Хүний эрүүл мэндэд харш үйл ажиллагаа явүүлж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэний талаар холбогдох байгууллагад өргөдөл, гомдол гаргах;

- Эрүүл мэндийн боловсролоо дээшлүүлэх зорилгоор эрүүл мэндийн байгууллага, ажилтнаас мэдээлэл авах;
- Хуулийн хүрээнд өөрийн эрүүл мэндтэй холбоотой мэдээллийн нууцыг хадгалуулах.

Транс хүлээн зөвшөөрөх өдрүүд:

Трансжендер болон ЛГБТИК+ хүмүүсийн асуудлыг хүлээн зөвшөөрч, мэдлэгийг дээшлүүлэхэд зориулсан жилд хэд хэдэн өдөр, сар байдаг. Эдгээр өдрүүд нь бэлгийн болон хүйсийн цөөнх хүмүүсийн талаар ихэвчлэн боловсрол олгох, олон нийтэд таниулах, мөн онцлог байдлыг тэмдэглэх боломжийг олгодог. Эдгээр он сар өдрүүд жил бүр өөр өөр байж болох бөгөөд шинээр тэмдэглэлт өдрүүд гарч ирэх магадлалтай гэдгийг санаарай.

1. Олон улсын Трансжендер өдөр (ОУТӨ):

Огноо: 3-р сарын 31

Зорилго: Трансжендер болон хоёр туйлт жендэрт үл нийцэх хүмүүсийн ололт амжилт, хувь нэмрийг үнэлж, тэмдэглэхийн зэрэгцээ тэдэнд тулгарч буй ялгаварлан гадуурхалтын талаарх мэдлэгийг дээшлүүлэх.

2. Лесбиян харагдах байдлын талаарх мэдлэг дээшлүүлэх өдөр:

Огноо: 4-р сарын 26

Зорилго: Нийгэмд лесбиян эмэгтэйчүүдийн харагдах байдлын талаарх мэдлэгийг дээшлүүлэх, баярыг тэмдэглэхэд анхаарлаа хандуулдаг.

3. Гомофоби, трансфоби, бифобийн эсрэг олон улсын өдөр (ИДАНО):

Огноо: 5-р сарын 17

Зорилго: ЛГБТИК+ хүмүүсийн эсрэг ялгаварлан гадуурхах, хүчирхийллийн талаарх мэдлэгийг дээшлүүлэх, хүлцэл, хүндэтгэл, эрх чөлөөний ертөнцийг дэмжих олон улсын арга хэмжээг зохицуулах зорилготой.

4. Бахархлын сар:


Огноо: Сар: 6-р сар

Зорилго: 1969 оны 6-р сарын сүүлчээр болсон Стоунволлын үймээн самууныг дурсаж, ЛГБТИК+ эрхийн хөдөлгөөний чухал үе гэж тооцогддог. Бахархлын сар бол ЛГБТИК+ олон нийтийг тэмдэглэж, эрх тэгш байдлыг хамгаалах өдөр юм.

5. Бисексуал үзэгдэх өдөр:

Огноо: 9-р сарын 23

Зорилго: Бисексуал олон нийтийн талаарх мэдлэгийг дээшлүүлж, хэвшмэл ойлголтыг сорьж, харагдах байдал, ойлголтыг дэмжих.



6. Үндэсний каминаут өдөр:

Огноо: 10 сарын 11

Зорилго: ЛГБТИК+ хүмүүсийг гарч ирж, түүхээ хуваалцахыг дэмжих, ЛГБТИК+ үзэгдэх байдлын ач холбогдлын талаарх ойлголтыг нэмэгдүүлэх.

7. Трансжендерийг дурсах өдөр (ТДӨ):

Огноо: 11 сарын 20

Зорилго: Трансжендерийн эсрэг хүчирхийллийн улмаас амиа алдсан трансжендер хүмүүсийн дүрсгалыг хүндэтгэх. Энэ нь мөн трансжендэр олон нийтэд тулгараад байгаа хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтын талаарх мэдлэгийг дээшлүүлдэг.

8. ДОХ-той тэмцэх дэлхийн өдөр:

Огноо: 12 сарын 1

Зорилго: ХДХВ/ДОХ-ын талаарх мэдлэгийг дээшлүүлэх, халдвар авсан хүмүүсийг дэмжих, өвчнөөр нас барсан хүмүүсийг дүрсан санахад чиглэнэ. Энэ нь мөн ХДХВ-тэй холбоотой гүтаан доромжлолыг эсэргүүцэх өдөр юм.

ЛГБТИК+ хүмүүстэй холбоотой асуудлуудыг танин мэдэх, хүлээн зөвшөөрөх нь тодорхой өдөр, сараар баригдах ёсгүй гэдгийг санаарай. Тасралтгүй боловсрол олгох, дэмжлэг, нөлөөлөл үзүүлэх нь бэлгийн чиг баримжаа, хүйсийн онцлогоос үл хамааран бүх хүмүүст хүртээмжтэй, баталгаатай орчинг бүрдүүлэхэд хувь нэмэр оруулдаг зүйл билээ.

Олон нийтийн сүлжээ ашиглаж олон нийтэд хүрэх нь:

Олон нийт үе тэнгийнхэндээ эерэгээр нөлөөлж чадах нэр хүндтэй трансжендэр нөлөөлөгч эсхүл олон нийтийн сүлжээнд тохиромжтой нөлөөлөгчдийг тодорхойлж олон нийтийг халдвар илрүүлэх шинжилгээнд өргөнөөр оролцохыг уриалах юм.

Өөрөөр хэлбэл, хүний эрх болон эрүүл мэндийн чиглэлээр үнэн зөв мэдээллийг түгээх, мэдлэгийг дээшлүүлэх, олон нийтийн оролцоог дэмжих зорилгоор эдгээр олон нийтийн сүлжээний нөлөөлөгчидтэй хамтран ажиллана гэсэн үг.

Мөн түүнчлэн, Сэтгэл зүйн гэмтэл авсан, сорилт бэрхшээлийг даван туулсан олон нийтийг нөлөөлөгчдөөр элсүүлж авч тэр хүмүүсийн түүхийг хуваалцаж болно.

Ингэснээр хувь хүнд тулгарсан бодит түүх нь ижил төстэй бэрхшээл тулгараад буй олон нийтэд хүрч, нөлөөлөх юм.

Сэтгэцийн эрүүл мэндийн мэргэжилтнүүдийг олон нийтийн сүлжээнд мөн татан оролцуулж болно. Сэтгэцийн эрүүл мэндийн мэргэжилтнүүдтэй хамтран трансжендер хүмүүст түгээмэл тулгардаг сэтгэл зүйн гэмтлийн талаар ярилцах энэ чиглэлийн эрүүл мэндийн үйлчилгээг нийтэд хэвийн үзэгдэл гэдгийг ойлгуулах.

Трансгендер олон нийтийн дунд үе тэнгийнхний нөлөөллийн хөтөлбөрүүдийг бий болгож, хувь хүмүүст өөрсдийн эрх ашгийг хамгаалах, үе тэнгийнхэнд боловсрол олгох, дэмжлэг үзүүлэх сүлжээг бий болгох нь сүүлийн үед олон улс даяар хэрэгжиж буй амжилттай арга барилуудын нэг болоод байгаа билээ.

Трансгендер олон нийтийн хамгийн их ханддаг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, платформуудыг тодорхойлох өөрийн түвшинд судалгаа хийх. Текст, зураг, видео эсвэл шууд дамжуулалт(Live) зэрэг харилцааны арга хэрэгслийг ашиглаж болно.

Мультимедиа контент, түүх ярих, хувийн амьдралын туршлагаа ашиглан олон нийтэд нийцэхүйц өгүүлэмжийг бий болгож бусад транс олон нийтэд нөлөөлөх дижитал орчинд нөлөөллийн кампанит ажил хийх нь бас олон улсад шалгарсан нөлөөллийн арга болсон билээ.



Ном зүй:

1. О.Мөнхсайхан, Монгол улсын үндсэн хуулиар хамгаалагдсан үндсэн эрхийн хүрээг тодорхойлох нь, УБ хот 2016 он, хүний эрх онол арга зүйн сэтгүүл дугаар 01
2. Баярцэнгэл, Хувь хүний эрх, эрх чөлөөний үндсэн хуулийн эрх зүйн зохицуулалт, УБ хот, 1999 он, хууль зүйн ухааны магистрын зэрэг горилсон судалгаан ажил
3. Хууль зүйн яам Монгол улсын үндсэн хуулийн нэр томъёоны дагалга, УБ хот 1993 он, Монгол улсын үндсэн хуулийн тайлбар, УБ хот, 2000он,
4. Г.Совд Монгол улсын үндсэн хууль, хүний эрх (Харьцуулсан эрх зүй, УБ хот, 1999он)
5. Д.Лүндээжанцан, Ч.Энхбаатар Монгол улсын Үндсэн хуулийн эрх зүй, УБ хот
6. Г.Агар-эрдэнэ нар Хүний эрхийн товч тайлбар, УБ хот 2012
7. С.Нарангэрэл, Эрх зүйн эх толь бичиг
8. Бэлгийн эрүүл мэндийн сургалтын гарын авлага, УБ хот, 2022
9. Эрсдэлт бүлгийн хүн амын дундаж ХДХВ-ийн халдварын нөхцөл байдлыг ойлгох нь гарын авлага 2023
10. Сэтгэл зүйн гэмтэл ба эдгэрэлт: Хүчирхийллийн үр дагавар - Жудит Льюис Хермань, АНУ улс 2022

